



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-9

1. *“Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл* 4-7
2. *Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал* 7-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 03 дугаар сарын 21-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ж.Эрдэнэбат;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Мөнхбат.*

Нэг. “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооноос Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын сонсгол даргалагчийг Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийг томилох саналыг танилцуулав.

Н.Энхболд: Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийг сонсгол даргалагчаар томилох гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Н.Энхболд: “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасны дагуу санал хураалтыг илээр явуулав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Жамьянгийн Мөнхбатын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ, УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 20 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

19 гишүүнээс 11. А.Адьяасүрэн гишүүнээс одоо ингээд картаа хийгээд 11 хүн ирээд ирц бүрдсэн учраас Байнгын хорооны 2023 оны 03 сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Нэг. “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

“Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлнэ.

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулна. Нэр дэвшигчдийн талаар материалыг тараасан байгаа.

Тодорхой байгууллагуудаас нэр дэвшүүлдэг. Энэ удаа Засгийн газраас Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшүүлэх орон гарсан 2 орон тоон дээр 2 хүний нэр ирүүлсэн байгаа. Үүнийгээ танилцуулаад тэгээд дараа нь тогтоолын

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцсэн.

Нэгдүгээрт, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын товыг зарлана. Сонсгол даргалагчийг томилно.

Энэ тухай Байнгын хорооны тогтоол гарах ёстой.

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал байгаа. Хэлэлцэх асуудал дээр саналтай хүн байна уу? Алга байна.

Горимын дагуу нэмж санал гаргасан зүйл байхгүй учраас хоёр асуудлаа батлаад ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

төслөө бас Та бүхэнд танилцуулаад ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Засгийн газраас санал өргөн мэдүүлэх тухай.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.7-д заасныг үндэслэн Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нарыг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү гэсэн Засгийн газрын бичиг Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдаас ирсэн. Энэ дагуу сонсголыг.

Эхлээд бид сонсголынхоо товыг зарлах ёстой. Ийм хуультай. Энэ хуулийнхаа дагуу өнөөдөр асуудлаа хэлэлцэж товоо зарлана.

Би тогтоолын төсөл тараасан. Тэгэхдээ Та бүхэнд уншаад танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлсэн Нямдаваагийн Монсор, Жаргалсайханы Золзаяа нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2023 оны 04 сарын 24-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр

дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийг томилсугай.

3. Нэр дэвшигчид хандан асуух асуулт, саналыг 2023 оны 04 сарын 10-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4. Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж холбогдох хууль, дүрэмд заасны дагуу зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух, санал хэлэх байвал гишүүд нэрээ өгье.

Дараа нь бид санал хурааж тогтоолоо батална. Энэ дотор тогтоолын дагуу нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар томилох гишүүнээ батлах ёстой.

М.Оюунчимэг гишүүнийг тасаллаа. Асуулт, санал хоёр нэг шүү. М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая.

Орж ирж байгаа 2 хүний тухайд одоогоор хэлэх үг алга. Яагаад гэвэл нэг их сайн мэдэхгүй юм байна. Засгийн газраас квотынхоо хүрээнд оруулж ирж байгаа юм байна.

Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны хариуцах асуудлын хүрээнд энэ Олон нийтийн радио, телевиз, энэ Үндэсний зөвлөл байдаг.

Тэгээд өмнөх намрын чуулганы үеэр Ё.Баатарбилэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарсан. Энэ ажлын хэсэгт манай Г.Ганболд гишүүн, би, Б.Пүрэвдорж гишүүн гээд гишүүд ороод, бид холбогдох хүмүүстэй удаа дараа уулзалт хийгээд Үндэсний зөвлөлд хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Энэ хугацаа дуусчихсан.

Яг энэ хугацааны хүрээнд өгсөн үүрэг даалгаврын нэг нь ч биелэгдээгүй байна гээд Телевизийн хамт олны зүгээс Ё.Баатарбилэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг рүү ингээд байн байн хандаад байдаг.

Тэгээд ер нь тэгээд Олон нийтийн радио, телевиз цаашдаа ийм статустай явах юм уу, үгүй юу. Энэ Үндэсний зөвлөл гээд л бид томилоод л байдаг. Тэгээд ямар ч хариуцлага хүлээхгүй. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх эрх зүйн чадавх байгаа эсэх нь тодорхойгүй.

Тэгээд тэр Үндэсний олон нийтийн радио, телевизийн удирдлагын хувьд ажилчдынхаа цалин хөлсийг тодорхой хэмжээгээр нэмэх, энэ олон ашиггүй байгаа сувгуудын заримыг нь больж, ажиллах сувгуудаа ашигтай болгох гэх мэт чиглэлүүд өгсөн. Одоо яг хэвээрээ л байгаад байх шиг байна л даа.

Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо энэ ажлын хэсгийн тайлангаа нэг сонсоод, энэ Үндэсний зөвлөлд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нь нэг сонсоод, тэгээд дараагийн томилох. Мэдээж нээлттэй сонсголын үеэр асуудлууд бас хөндөгдөх байх.

Ер нь энэ Үндэсний зөвлөлөө чанаржуулах, ер нь цаашдаа тэгээд байх юм уу, байхгүй юм уу. Байхаар бол яах вэ

гээд энэ асуудлуудаа бас нэг энэ ажлын хэсгийн хугацаа нь одоо бараг болчихсон байхгүй юу. Тэгээд өгсөн үүрэг даалгавар маань ч ямар байна энэ тэр гэдгээ нэг ярих хэрэгтэй байна л даа.

Тэгэхээр энэ дээр хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа болов уу? Энэ дээр ямар бодолтой байгаа бол гэсэн асуултыг асууя. Баярлалаа.

Н.Энхболд: М.Оюунчимэг гишүүний саналыг бүрэн дэмжиж байна. Үүний өмнө бид энэ асуудлыг ярихад бас нэлээд дэлгэрэнгүй нухацтай ярианууд явж байж Байнгын хороон дээрээс ажлын хэсэг томилсон. Тодорхой үүргүүд өгсөн байгаа.

Тэгэхээр ингэе. Байнгын хорооноосоо албан тоот явуулаад. Байнгын хороо явуулах уу. Харин ажлын хэсгээс явуулах уу. Байнгын хорооноосоо явуулчихъя. Албан ёсоор Байнгын хорооноос өгсөн юм чинь.

04 сарын 24-н буюу сонсгол болохоос өмнө энэ талаар өгсөн үүргүүдийн биелэлтийн гүйцэтгэлийг гаргаж Байнгын хороонд ирүүлсэн бай гэдэг даалгавар өгөөд. Тэгээд ажлын хэсгийн гишүүд ч гэсэн энэ чиглэлээр өөрсдөө ажиллаад шахаад шаардаад. Ямар ч байсан сонсголоос өмнө тайланг нь авъя. Гүйцэтгэлийн тайлан авъя.

Тэгээд тэр бас бид нарыг тэр хүмүүсийг томилох асуудлыг хэлэлцэх үеэр бас яриа санал онолын үндэс болох юмнууд гарч ирэх ёстой. Ингэж тогтъя. Байнгын хорооны ажлын хэсэг энэ дээр анхаарал тавиад бичиг төлөвлөөд Үндэсний зөвлөлийн даргад явуулчихъя.

Тогтоолтой холбоотой асуудлаар гишүүд асууж санал хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт байгаа. Санал асуулт нэг гээд явчихсан. Түрүүн бүр анхааруулж хэлсэн. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр. Хэрэв Үндэсний зөвлөл үнэхээр ажиллаж чадахгүй байгаа бол одоогийн байгаа хууль тогтоомж, зохицуулалт нь хангалтгүй байгаа бол энэ хуулийг эргэж харах шаардлага гарна гэж.

Тэгэхээр тэр ажлын тайлан нь хүрээд ирэг. Тэгээд хэдүүлээ дахиж ярьж байгаад түрүүчийн ярьсан асуудлуудынхаа мөрөөр яах вэ гэдгээ сонсголтой холбогдуулаад бас нэг ярилцах шаардлага гарах байх гэж бодож байна.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх энэ сонсгол даргалагчийн талаар санал хураах ёстой. Дэгээрээ.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийг томилъё гэсэн санал гаргаж байна. Байнгын хорооны зүгээс энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

12 гишүүнээс 9 нь дэмжиж, 75.0 хувиар Ё.Баатарбилэг гишүүнийг сонсгол даргалагчаар томилохыг дэмжлээ.

Одоо тогтоолоо бүхэлд нь батлах санал хураалт явуулья. Түрүүн уншиж танилцуулсан. Их Хурлын Байнгын хорооны тогтоолыг.

“Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” тогтоолыг баталъя гэсэн саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

12-оос 9 дэмжиж, 75.0 хувийн саналаар тогтоол батлагдаж байна.

Нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал

Хоёрдугаар асуудалдаа орёе. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай асуудал байгаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хандаж 2023 оны 01 сарын 30-ны өдөр хүсэлт гаргаж өргөдөл ирүүлсэн.

Өргөдлийг би уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамъян овогтой Мөнхбат миний бие Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1.2 дахь заалтыг үндэслэн. Энэ заалт нь хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн авч зөвшөөрсөн бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно гэсэн заалт байгаа.

Энэ заалтыг үндэслэн дараах хүндэтгэх шалтгааны улмаас Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээсээ

татгалзаж, бүрмөсөн чөлөөлөгдөх хүсэлтийг гаргаж байна. Үүнд,

1.Настай ээжийн маань эрүүл мэндийн шалтгааны улмаас гадаадад эмчлүүлэх шаардлагатай болсон. Энэ нь хувь хүний эрүүл мэнд, зовлон жаргалтай холбоотой асуудал учраас олон нийтэд дэлгэрэнгүй тайлбарлах боломжгүй бөгөөд ээжээс төрсөн хүн бүр ойлгоно хэмээн итгэж байна.

2.Сүүлийн жилүүдэд намайг концесс, казино, нүүрс, үнэтэй цаг, машинтай гэх мэтчилэн олон асуудалд хилсээр нэр холбож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр зохион байгуулалтайгаар гүтгэн харлуулах ажлыг санаатайгаар маш их явууллаа.

Миний бие ямар ч хууль бус үйлдэл хийгээгүй гэдгээ удаа дараа хэвлэлээр тайлбарлаж байсан боловч буруутан, гэмтэн мэт сэтгэгдэл нийгмийн зарим хэсэгт үлджээ.

Тиймээс эдгээр асуудалтай холбоотойгоор хууль хяналтын байгууллагаас хэрвээ намайг шалгах шаардлагатай бол би Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дархан эрхийн ард байж нуугдалгүйгээр энгийн иргэн болоод шалгуулахад бэлэн гэдгээ энэхүү үйлдлээрээ илэрхийлж байгаа болно.

Монгол төрийг хариуцлагатай, шударга, зарчимтай, ёс суртахуунтай байх ёстой хэмээн шаардаж буй нийгэм, олон нийт, залуучуудынхаа шаардлагыг энэхүү үйлдлээрээ би дэмжиж байна.

Надад итгэлээ өгч дэмжин хоёр удаа Улсын Их Хурлын гишүүнээр сонгосон Архангайчууддаа болон төрийн сайд төрийн түшээгээр ажиллах

хугацаанд зөвийг маань дэмжиж, бурууг маань шүүмжлэн сургамжилж байсан Монголынхоо нийт ард түмэнд чин сэтгэлээсээ баярлан талархаж байгаагаа илэрхийлж мэхийн ёсолъё.

Миний энэхүү хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хүсэлт гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат гэсэн ийм өргөдөл ирсэн.

Одоо ингээд Ж.Мөнхбат гишүүний чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэж эхэлье.

Энэ хүсэлттэй холбогдуулаад асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна. /алх цохив/

Одоо санал хураал хураана. Ер нь зүгээр хуулийн тайлбар танилцуулахад гишүүний бүрэн эрх энэ хуулийн 7.3-д заасан хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэл гэдэг дээр 10.1.2-т хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөлдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн гэсэн нэг заалт.

10.3-д гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан асуудлаар гишүүн саналаа нууцаар.

Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.6-д заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батлагдсанд тооцно гэсэн ийм хуулийн зохицуулалттай.

Ж.Мөнхбат гишүүн маань өөрөө хүсэлтээ гаргаад чөлөөлөгдье гэж 10.1.2 гэсэн заалтыг үндэслэж өргөдлөө гаргасан учраас санал хураалтыг илээр явуулна.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Жамьянгийн Мөнхбатын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн дүн гарлаа.

Санал хураалтын дүнгийн дагуу тогтоолын төсөл бэлдээд Улсын Их Хурлын чуулганд би өөрөө танилцуулчихъя даа. Би өөрөө танилцуулчихъя.

Хуралдаанд ирж оролцсон гишүүддээ баярлалаа.

Тогтоолын төсөл ийм байх юм шүү.

Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 10.2, 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жамьянгийн Мөнхбатыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолыг танилцуулна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 16 минут үргэлжилж, 10 цаг 36 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД